

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** Газрын тосны терминал

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** “Трансгайд сервис” ХХК

**Регистрийн дугаар:** 5546168

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011327015


**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Багахангай дүүрэг 2-р хороо Замчдын 9-12 тоот

“Трансгайд сервис” ХХК нь 2015 оны 11 сарын 14-ийн өдрөөс эхлэн газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус компани Улаанбаатар Замын-үүд чиглэлын АЗ тоот хатуу хучилттай зам дагуу Багахангай дүүргийн 2-р хороонд 254×391м<sup>2</sup> хэмжээтэй нийт 10 га талбай эзэмшин үйл ажиллагаа явуулдаг. Терминалийн үндсэн үйл ажиллагаа нь бензин, дизель түлш зэрэг газрын тосны бүтээгдэхүүнийг вагонцистернээс хадгалах савруу, хадгалах савнаас автоцистерн эсвэл вагонцистернруу ачих зэргээр явагддаг.

Бүтээгдэхүүний хадгалах сав тус бүртээ ачилт хийх тусдаа шугамтай, долгион хэмжигч төхөөрөмж, савны галыг усаар хөөсөөр бүрэн унтраах системээр тоноглогдсон, ачих буулгах насос станцаар тоноглогдсон байна. Терминал нийт 24 ажилтантай бөгөөд 3 ээлжээр ажилладаг.

**Хүснэгт 1. Төслийн талбайн байршилын координат**

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	28	14.94	47	22	1.69
2	107	28	3.45	47	22	11.78
3	107	28	13.08	47	22	16.86
4	107	28	24.39	47	22	6.83



Зураг 1. Төслийн талбайн байр зүйн зураг

### **Төслийн хүчин чадал, тоног төхөөрөмж Ачих, буулгах насос станцын барилга**

16м\*6м-ийн харьцаатай 96м<sup>2</sup> талбай болон 20м\*6м-ийн харьцаатай нийт 120 м<sup>2</sup> талбай бүхий 1 давхар тоосгон барилгыг ГТБ-ийг ачих, буулгах зориулалт бүхий насос байрлуулан ашигладаг. Уг барилга нь дотроо дагалдах төхөөрөмж болох 5 насостой. Бүтээгдэхүүн хадгалах сав тус бүрийн хувьд ачилт хийх тусдаа шугамтай, долгион хэмжигч төхөөрөмж, савны галыг ус хөөсөөр бүрэн унтраах системээр тоноглогдсон.



Зураг 2. Нефтийн бүтээгдэхүүн ачиж, буулгах талбай

### **Лаг ууршуулах талбай**

Лаг ууршуулах талбай нь 20м\*40м-ийн хэмжээтэй, 9445м<sup>2</sup> талбайтай хонхор газарт байгуулсан, газрын гадаргуугаас доош 0.5 м-ийн гүнд ухаж гадаргууг битүү цементэлсэн талбай юм. Уг талбай нь асгарсан бүтээгдэхүүнийг трапаар цуглуулж хадгалах зориулалттай юм. 2015 онд ашиглалтанд оруулсан.

### **Конторын барилга**

35м\*14м-ийн нийт 490м<sup>2</sup> талбайтай, 11 өрөө бүхий 1 давхар барилгыг офиссын зориулалтаар ашигладаг. Тус барилга нь 2015 онд ашиглалтанд орсон бөгөөд ямар нэг эвдрэл гэмтэл байхгүй, их засвар хийгээгүй болно.

### **Гурван ширхэг босоо сав**

Тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагаандаа газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зорилгоор 2700м<sup>3</sup>-ын 2 /АИ92/ , 3500м<sup>3</sup>-ын 2 /Дизель түлш/ ширхэг босоо савуудыг 2015 оноос хойш ашиглаж байгаа. 2022 онд АИ92 хадгалах бүхий 700м<sup>3</sup>-ын 4 ширхэг босоо савыг нэмж ашиглаж байна.

Тус савнууд нь газар доогуурх шугамаар ачих, буулгах станц руу холбогдсон байдаг бөгөөд вагоноос бүтээгдэхүүнийг буулгах, автоцистерн руу ачих зэрэг үндсэн үйл ажиллагаа явагддаг.



**Зураг 3. Газрын тосны бүтээгдэхүүн агуулах босоо савнууд /2022 онд ашиглалтад орсон 700.0м3 багтаамж бүхий 4ш босоо сав/**

### **Галын хөөс, усны станцын барилга**

4м\*9м-ийн хэмжээтэй 1 давхар тоосгон барилга бөгөөд “Трансгайд Сервис” ХХК нь галын аюултай объект гэж тооцогддог учраас гал унтраах зориулалт бүхий нөөц ус, хөөсний насосыг байрлуулдаг. Нийт 5 тонны хэмжээтэй ус, хөөсний багтаамжтай. Зоорийн хэсэгтэй.



Зураг 1. Гал унтраах хэрэгслүүд


500м3\*2 ширхэг төмөр бетон усан сан: Газрын гадаргуугаас доош 6м-ийн гүнд ухаж бетон цутгаж доторлосон бөгөөд онцгой байдлын үед галын аюулгүй байдлыг хангах зорилгоор нөөц галын хөөс, ус хадгалах зориулалтаар ашиглагддаг.

### Төслийн үйл ажиллагааны технологи

#### *Шатахууныг вагоноос хүлээн авах*

Вагоны талбайд байрлуулж хэмжилт хийж газардуулсны дараа буулгах шланг хийн буцаах системийн хоолойг холбож шатахууны хаалтуудыг нээх ба буулгаж дууссаны дараагаар хаалтуудыг хаана.

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөр баталгаажуулсан шингэний тоолуур, мерник, сүмбэнметртэй байна. Вагоноор тээвэрлэж ирсэн шатахууныг битүүмжилсэн технологийн шугам хоолойгоор насосны тусламжтайгаар нөөцлөх саванд хүлээн авч хадгална.



Зураг 2. Технологийн зарим үйл ажиллагаа

### **Зам талбай**

Ерөнхий төлөвлөгөөг захиалагчийн эзэмших газрын хил, дэвсгэр зургийг үндэслэн зохиосон байна. Зам талбайд ус орохоос хамгаалагдсан байх, мөн хур тунадасны ус тогтоол үүсгэхгүй, шатахууны сав, худаг, барилга байгууламж болон тусгай талбайд орохгүй байхаар тооцож төлөвлөсөн байна. Дээр дурдсан барилга байгууламжуудын талбайгаас ялган авч үзвэл:

- ✓ Нийт зам талбай нь 15528 м<sup>2</sup> байна.
- ✓ Төмөр замын ачих, буулгах талбай:
- ✓ 12 зогсоолтой 2610 м<sup>2</sup>

### **Авто ачих стакадын талбай:**

Стакадын талбай нь 646 м<sup>2</sup> талбайтай юм. Шатахуун ачиж буй тээврийн хэрэгсэл зогсоход зориулсан цэнэглэх талбайн шатахууныг хөрсөнд нэвтрүүлэхгүй байх, асгарсан шатахуунд нэвчихгүй байх, галд тэсвэртэй байлгах үүднээс өндөр чанарын бетоноор хучилт хийнэ. Ачих талбай нь эргэн тойрны талбайгаас хур тунадасны ус урсаж орохгүй байхаар зураг төсөл тусгасан байна.

Мөн стакадын орчинд шатахуун асгарсан тохиолдолд талбайгаас бусад талбай руу алдагдахгүй, хөрсөнд шатахуун нэвчүүлэхгүй байхаар төлөвлөнө.

### **Үйлчилгээний барилга**

Төслийн үйл ажиллагааг удирдах, автоматаар хянах зориулалтаар бүхий үйлчилгээний байр төлөвлөжээ. Үйлчилгээний байр /операторын/ нь гал тэсвэршлийн Н-р зэргийн шаардлагыг хангах ёстой.

### **Шатахуун хадгалах сав**

Шатахууны агуулахад зориулсан 3500 м<sup>3</sup> багтаамжтай 2 ш босоо ган, 2000 м<sup>3</sup> багтаамжтай 2 ш босоо ган, нийт 4 ш босоо савыг суурилуулна.

Саванд технологийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах иж бүрэн тоноглол суурилуулсан байна.

### **Технологийн хоолой**

Технологийн хоолойг газар дор угсрахаар зураг төсөлд тусгасан байна. Технологийн хоолойг нефтийн бүтээгдэхүүнд ашиглахад зөвшөөрөгдсөн ган хоолойгоор угсарна. Холбох хэрэгсэл нь ган хоолойн шинж чанараас дутуугүй үзүүлэлт бүхий гангаар хийгдсэн байх юм. Технологийн хоолойн угсралтын үеийн холболтын гагнаасын бөх батын чанарын үзүүлэлт нь ган хоолойн үзүүлэлтээс багагүй байна.

Технологийн хоолойн ажлын дээд даралт 0.3 МПа байхаар тооцов. Сорох технологийн хоолойн налуу технологийн худаг уруу чиглэсэн байна. Хоолойг угсарч дууссаны дараа ажлын дээд даралтыг 1.25 дахин буюу 0.4 МПа даралтаар 5 минутын туршид шалгах бадараа нь даралтыг ажлын даралтын хэмжээнд бууруулан шалгалтыг 15 мин үргэлжлүүлнэ.

### **Агааржуулалтын хоолой**

Тухайн төрлийн шатахууны савны амьсгалах клапан буулгах төхөөрөмжийн хийн буцаах системийн хийн хоолойг холбож агааржуулалтын хоолой үүсгэнэ. Агааржуулалтын болон технологийн хоолойд тавигдах бүх шаардлага тавигдана.

### **Буулгах төхөөрөмж**

Шатахуун тээвэрлэн ирсэн вагоноос шатахууныг саванд хүлээн авахад зориулагдсан төхөөрөмжийг буулгах талбайн дэргэд байрлуулсан байна.

### **Терминал дахь технологийн дамжуулах хоолой**

Технологийн дамжуулах хоолойн системийн зураг төсөл, угсралтыг бүхэлд нь АМИХБи(В) 31.3 дүрэмд заасны дагуу гүйцэтгэнэ.

“М” ангиллын шингэнд тавигдах шаардлагуудыг(АМИХ Би(В)31.3) зураг төсөлд харгалзан үзнэ. Нүүрстөрөгчит гангсуурь материалаар ашиглана.

Технологийн дамжуулах хоолойн хананы зузаан нь 40 мм-ээс багагүй байна.10%-ийн рентген зурган сорилтыг бүх зэрэглэлийн бүтээгдэхүүнд хийнэ.

Савнуудын дүүргэх хоолой буюу орлого, түгээх хоолой буюу зарлагын хоолойн хошуу, цоргон дээрх үндсэн хавхлагууд нь бөмбөлөг, бөглөө гэх мэт шуурхай хаалтан хавхлага байна.

Аюулгүй байдлыг хангах үүднээс эсхүл үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудын улмаас өөрөөр анхааруулан тэмдэглээгүй буюу шаардаагүй бол бусад хэрэглээнд хаалтан хавхлага ашиглаж болно.

Сонголтот хувилбар: савнуудын орлого, зарлагын хоолойн хавхлагууд дээр хөтлүүр механизм суурилуулж болно.

### **Ослын сав**

Талбайд аваар ослын байдлаар шатахуун асгарсан тохиолдолд цуглуулан авах ослын 10 м<sup>3</sup>-ийн багтаамжтай савыг дамжуулах хоолойн хамт суурилуулахаар тусгасан байна.

### **Аянга зайлуулагч**

Шатахууны агуулах, барилга байгууламжийг аянганаас хамгаалах зорилгоор 6 ш аянга зайлуулагч, тэдгээрийг газардуулах хэрэгслийг суурилуулна.

Хадгалалтын явцад технологийн үндсэн шаардлагууд, түүний дотор резервуар, түүнд тавигдах технологийн шаардлагыг ММ5 4633- 98 стандартын нэгдүгээр бүлгийн 1.4- т тусгасан байдаг.

### **Шатахууныг саванд хадгалах**

Савны дүүргэлтийн дээд хязгаар нь савны паспортанд тусгайлан заагаагүй тохиолдолд бодит багтаамжийн 95 хувиас хэтрэх ёсгүй. Ашиглалтын ердийн нөхцөлд сав бүрэн битүүмжлэгдсэн, агаарын солилцоо зөвхөн амьсгалах клапангаар дамжин явагдах ёстой. Хадгалалтын үед саванд байгаа шатахууны түвшинг автоматаар буюу компьютерийн дэлгэцээр хянана. Шатахууны хувийн

жин, температурыг зөөврийн багажаар савнаас зохих журмын дагуу авсан дээжийг хэмжих аргаар тодорхойлно.

**Хүснэгт 2. Барилга байгууламж, тоног төхөөрөмж, технологи**

1.	Төмөр замын салаа	700 м
2.	Трансформатор	1 ш
3.	Сендвичин барилга	1 ш
4.	Котейнер	1 ш
5.	Бетонталбай	577 м <sup>2</sup>
6.	Угсармал бетон хашаа	1390у/м
7.	Худаг	1 ш
8.	Автозам	600 м
9.	Конторын барилга	29х14 м
10.	Агуулахын барилга	17.7х13.2 м
11.	Автомашинны граш	23.0х6.0 м
12.	Удирдлагын байр	1 Ш
13.	Харуулын байр	1 ш
14.	Төмөр замын ачих, буулгах талбай	12 зогсоолтой
15.	Насосстанц	20.0х6.0 м
16.	Босоо ган сав 3500 м <sup>3</sup> багтаамжгай /Дизель/	2 ш
17.	Босоо ган сав 2000 м <sup>3</sup> - ийн багтаамжгай/Авто бензин/	2 ш
18.	Босоо савны паркийн төмөр бетон далан	256.7у/м
19.	Босоо савны паркийн бетон талбай	2610 м <sup>2</sup>
20.	Далангаар гарах шат	4 ш
21.	Авто ачих стакадын арал	3 ш
22.	Авто ачих стакадын саравч	1 ш
23.	Шатахуун ачих бетон талбай /646 м <sup>2</sup> /	34.0х19.0 м
24.	Шугам хоолой суллах хэвтээ далд сав /500 м <sup>3</sup> /	2 ш
25.	Галын усан сан /500 м <sup>3</sup> /	1 ш
26.	Галын ус, хөөсний насос 4.5 х 4.0 м	1 ш
27.	Ууршуулах талбай 800 м <sup>2</sup>	1 ш
28.	Шаврын талбай 165 м <sup>2</sup>	16.5 х 10.0 м
29.	Явган хаалга	1 ш
30.	Технологийн авто машины хаалга	1 ш
31.	Галын автомашины хаалга	1 ш
32.	Технологийн авто машины зам талбай	1200 м <sup>2</sup>
33.	Галын автомашины зам талбай	1200 м <sup>2</sup>
34.	Вагон цистерний хаалга	1 ш



## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### *Төсөл хэрэгжих орчны уур амьсгал:*

Төсөл хэрэгжих нутаг нь уур амьсгалын мужлалтаар хуурайдуу, сэрүүн зуны мужид багтах бөгөөд хахирдуу өвөлтэй хүйтэн дэд мужид хамаарна.

Цаг уурын үүднээс авч үзвэл судалгааны нутаг нь Дорнод Монгодын цаг уурын мужид хамрах бөгөөд маш хүйтэн өвөл бүхий эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт хамгийн ойр орших Төв аймгийн Баян сумын цаг уурын мэдээг энд ашиглалаа.

Уур амьсгалыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл болох нарны энергийн хувьд нарны нийлмэл цацраг 6-р сард 554-650 МДж/м<sup>2</sup>, 12-р сарынх 137-150 МДж/м<sup>2</sup>, жилийнх 5000 МДж/ м<sup>2</sup> тус тус байна.

### *Агаарын температур*

Агаарын жилийн дундаж температур 1.25 хэм, 1-р сарын дундаж -21 хэм, 7-р сарын дундаж 17.7 хэм орчим байна. Дулааны улирал 5-р сараас 10-р сарын эх хүртэл, хүйтний улирал 11 сараас 4 сар хүртэл үргэлжилнэ.

Их хүйтэн өдөр 20-30, их халуун өдөр 10-20 байх магадлалтай. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 90-110 өдөр. Хаврын цочир хүйтрэл 5-р сарын 27-ноос 6-р сарын 1, хамгийн эрт 5-р сарын 18, хамгийн хожуу нь 6-р сарын 5-нд тохиолдоно. Намрын анхны дундаж хүйтрэлт 9-р сарын 4, намрын анхны хамгийн эрт хүйтрэлт 9-р сарын 2-нд, хожуу нь 9-р сарын 29-нд болно.

Агаарын үнэмлэхүй бага температур -25<sup>0</sup>С ба түүнээс бага утга 1986.12.25-нд 45.7<sup>0</sup>С хүрсэн бөгөөд хамгийн хүйтэн сарын үнэмлэхүй хамгийн багын дундаж -35.6<sup>0</sup>С байдаг.

Энэ нутагт дулааны улиралд хур тунадасны ихэнх хувь нь 91% буюу 252.1мм, хүйтний улиралд маш бага 9 хувь буюу 25.1мм нь ордог байна.

Төв аймгийн Баян сум орчмоор бусад нутгаасаа арай бага жилдээ 236 мм хур тунадас унадаг байна. Жилийн доторхи хувиарлалтыг авч үзвэл 6-8-р саруудад хамгийн их хур тунадас унана. 6-р сард 34.2мм-58.6мм хур тунадас, 7-р сард 72.9-86.7мм, 8-р сард 59.3-77.9мм хур тунадас унадаг байна. Зуны 42-50 өдөр бороотой, аянган уур амьсгалын 2-р мужид хамаарах бөгөөд 22-36 өдөрт аянга цахилгаантай бороо 46 цаг орчим (хамгийн удаан нь 100 цаг) үргэлжлэн, 1 аянга 94 минутын үйлчлэлтэй 1 км<sup>2</sup> талбайд 5-6 удаа ниргэлт болж орд, техник хэрэгсэл, хүмүүсийн үйл ажиллагаа хөдөлмөрийн нөхцөлд түр саатал бэрхшээл, улмаар аюул тохиолдож болох эрсдэлтэй

Өвлийн улиралд хур тунадас бага утгандаа хүрч 0.8-6.1 мм байна. Цас орох өдрийн тоо 20. Тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацааны дундаж XI/20-XII/1, хамгийн эрт нь X/20, хамгийн хожуу нь I/10. Цасан бүрхүүлийн дундаж хамгийн их зузаан 10 см орчим. Цасан бүрхүүл ханзарч эхлэх хугацааны дундаж

нь II/10-III/1, хамгийн эрт нь I/23, хамгийн хожуу нь III/16 бөгөөд тогтвортой цасан бүрхүүлийн үргэлжлэх хугацаа 75-80 хоног байна.

Иймд аянга, борооноос хүмүүс, аж ахуйн орчныг хамгаалах шаардлага тавигдана.Зарим жилийн өвлийн саруудад хоногоор үргэлжилсэн их цас орж зам тээврийн саатал гардаг. Хэвтээ гадаргад цасны ачаалал 50 кг/м<sup>2</sup> хүрэх боловч их цасны үед үүнээс ч давна. Жил бүрийн IX-IV сарын 125-130 хоногт тогтвортой цасан бүрхүүл тогтож, ихэвчлэн 5-10 см, зузаарсан үедээ 15-20 см, дунджаар 0.18-0.20 г/см<sup>3</sup> нягттай, 8-12 мм орчим нөөц услагтай байна. Энэ нь хавар гэсэхдээ төдийлөн нөөц чийгийг нэмэгдүүлж чаддаггүйг харуулна.

### Агаарын даралт, салхи

Салхи ихэвчлэн баруун хойд чиглэлтэй бөгөөд жилийн дундаж хурд 3.5-4.0 м/с, саруудын хамгийн их хурд 5, 4-р сард оногдох бөгөөд 5 м/с-ээс дээш байна.Хүчтэй салхитай өдрийн тоо 10-20 бөгөөд шороон шуурга 10-20 одөр тохиолдоно. Гадаргаас 10 м өндөрт салхины хурдын шахах хүч 35-45 кг/м<sup>2</sup>, нэг удаа тохиолдох тооцооны их хурд 28 м/с байх магадлалтай.

### Хөрсний температур

Хөрсний хөлдөлт, чийгшил хүйтэн сэрүүний улиралд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байдаг.

Тус район хөрсний хөлдөлт, гэсэлтийн уур амьсгалын 3-р мужид хамаарах бөгөөд хөлдөлт X/20-31-нээс эхэлж III/15-IV/30-нд дуусах бөгөөд 160 хоног үргэлжилнэ. Гэсэлт III/25-IV/1-нд эхэлж IV/15-V/31-нд дуусаж дунджаар 35 хоног үргэлжилнэ. 0°С-ийн нэвчих гүн 250 см байна. Хөрсний гүний олон сар, жилийн дундаж температурыг хүснэгт 3-аар үзүүлэв.

Хүснэгт 3. Хөрсний гүний сар, жилийн дундаж температур (1960- 2000 он)

Сар Гүн, м	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Жил
0.2	-16.4	-14.8	-7.9	1.3	9.9	15.4	18.0	16.6	11.3	4.8	2.5	-11.0	1.8
0.4	-14.0	-13.8	-7.6	-0.4	7.5	13.3	16.2	15.7	11.8	5.9	2.0	-9.0	1.6
0.6	-11.5	-12.4	7.8	-1.8	5.1	11.2	14.2	14.6	11.4	6.4	0.4	-6.2	2.5
0.8	-9.5	-11.0	-7.6	-2.5	3.6	9.4	12.8	13.7	8.1	7.6	1.2	-4.2	3.0
1.2	-7.3	-9.4	-7.4	-3.2	1.8	7.4	10.6	11.7	10.7	7.5	2.7	-2.1	1.9
1.6	-3.4	-6.0	-5.8	-3.1	-0.3	5.0	7.9	10.0	10.1	8.0	4.6	0.7	2.3
2.4	0.1	-2.0	-3.2	-1.5	-1.2	0.8	3.7	6.0	7.4	6.9	5.2	2.6	2.0
3.2	2.0	0.6	-0.4	-0.8	0.4	0.1	2.0	4.4	6.0	6.3	5.5	4.0	2.4

Хөрсний улирлын хөлдөлтийн гүн 0.2-3.2 м хүрнэ. Хөрсний гадаргын дундаж температур 1-р сард -16.4°С, 7-р сард 18°С орчим байна.

Төслийн үйл ажиллагаанд дулааны улирлыг оновчтой тогтоон үнэлж эхэн, дунд, сүүл үед хуваах нь үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх нөхцөлийг зохистой сонгоход чухал ач холбогдолтой.

### Ус зүй:

#### Төсөл хэрэгжих орчны гидрогеологи

Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Газрын тосны бүтээгдэхүүний терминаль агуулах нь унд ахуйн хэрэгцээний усыг гүний худгийн уснаас хангахаар төлөвлөсөн байна. Төслийн хүрээнд худгаас зориулалтын шугам татаж нөөцлүүрийн саванд хуримтлуулан унд ахуйн болон гал унтраах зориулалтаар ашигладаг байна.

Талбайн орчмын геологи-гидрогеологийн нөхцөлийн хувьд гидрогеологийн давхрага зүйн ангилалаар дараахь уст үе давхрага, усны хуримтлалыг ялгаж байна. Үүнд:

*Дээд дөрөвдөгч болон орчин үеийн ангилагдаагүй сэвсгэр хурдсан дахь уст үе давхрага:* ( $Q_{III-IV}$ ) нь Хөндий болон ил урсацын гольдролын дагуу нилээд хязгаарлагдмал зурвас талбайд зонхилон тархсан байна. Энэ уст үе давхрагын ус агуулагч чулуулгийн литологийн бүрэлдхүүнд хайр, хайрга, линз маягийн нягтарсан шаврын биет, элсэнцэр, сайрганцарын хольц агуулсан үе давамгайлна. дөрөвдөгчийн болон орчин үеийн ангилагдаагүй сэвсгэр хурдасны уст үеийн зузаан 1.5-10.0 м бөгөөд энэ уст үеийн дотор агуулагдаж байгаа газрын доорхи ус нь ихэнхдээ 5.0-13.0 м-т усжсан хэлбэрээр илэрч газрын доорхи усны тэжээл нөхөн сэлбэгдэл нь зөвхөн агаарын хур тунадасны чөлөөт нэвчилтээр зонхилон хангагддаг бөгөөд дулааны улиралд гадаргуугийн бэсрэг урсацаас ч бас тэжээл авдаг.

*Дунд-дээд дөрөвдөгчийн сэвсгэр хурдсан дахь уст үе давхрага ( $Q_{II-III}$ ):* тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд уулс хоорондын хөндий, хотгор, гуу жалга болон бэл хормой орчмоор зонхилон тархах бөгөөд ус агуулагч чулуулгийн бүрэлдүүнд дайрга, сайрга, шаврын нимгэн үелэл голлох хувийг эзэлдэг. Энэ уст үеэр илэрсэн цооногийн усжилт бага байдаг бөгөөд уст үеийн зузаан газрын хотгор гүдгэрийн хэв шинжээс шууд хамааран харилцан адилгүй байдаг. Тархалтынхаа талбайн хэмжээнд унасан агаарын хур тунадасны чөлөөт нэвчилтээр тэжээгдэнэ. Газрын доорхи усны ерөнхий урсгалын чиглэл уулс хоорондын хөндий, хотгорын гадаргуугийн урсацын налууутай давхцан гадаргуугийн урсацын чиглэлтэй нэг чиглэлд байдаг.

*Палеозойн настай гүний чулуулаг дахь уст давхрага* нь бүс нутгийн хэмжээнд эргэн тойрон нийт талбайн 70-80 % -д тархсан байх бөгөөд уулс хоорондын хөндий, хотгор, нам дор газрын хүрээлэн өндөр уулсыг бүсийг бий болгож байна. Боржин, боржин сиенит, боржин диорит зонхилон тогтсон гүний чулуулгийн бүсийн дээд хэсэгт өгөршлийн ан цавын сүлжээ нилээд түгээмэл хэлбэрээр тархан гүний болон талбайн хэмжээнд харилцан адилгүй жигд биш тархсан байна. Ан цав бүхий чулуулгийн массив нь агаарын хур тунадасны чөлөөт нэвчилтээр тэжээгдэж буй болсон газрын доорхи усыг цуглуулан дамжуулан урсгах үүргийг гүйцэтгэдэг.

## Худаг

Тус гүний худгийг ахуйн болон галын аюул ослоос сэргийлэх гал унтраах хэрэглээнд зориулан гаргасан байна. Худгийн гүн нь 90м орчим, дтд 1466 м өндөр. Худгийн орчимд ургамалан нөмрөг бага, Багахангай дүүрэг явах хатуу хучилттай замын хажууд байрлалтай. худгийн ус өнгөгүй, үнэргүй харагдах байдал тунгалаг байна. Худгийн паспортыг хавсралтаар тусгав.

### Хүснэгт 4. Худгийн ерөнхий мэдээлэл

Худгийн нэр	Газарзүйн байршил	Өндөр, м	Цооногийн гүн, м	Ундарга, л/с	Статик түвшин, м
Гүний худаг 2	47°22'1.71"N 107°28'14.95"E	1466	90	4.2	12



Зураг 3. Гүний худаг

## Шинжилгээний дүн:

Шинжилгээний дүнгээс үзвэл химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, кальц магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү хатуувтар ус байна. Худгийн ус нь катионаас магни, калийн ион давамгайлсан, анионаас гидрокарбонат ионы агууламж давамгайлсан. Монгол Улсын ундны усны стандарт “MNS0900:2018”-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд зааснаас магни илүү бөгөөд бусад үзүүлэлтүүд хүлцэх хэмжээнээс хэтрээгүй байна.

### Хүснэгт 5. Усны химийн бүрэлдэхүүний тодорхойлолт

№	Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Үр дүн
1	pH-Усан орчин	6.5-8.5	6.90
2	Цахилгаан дамжуулах чанар	<1.0	0.85
3	Ерөнхий хатуулаг	<7.0	6.88
4	Кальци	<100.0	67.33
5	Магни	<30.0	<b>42.80</b>
6	Карбонат	-	0.00
7	Хлорид	<350.0	29.78
8	Гидрокарбонат	-	281.00

9	Нитрит	<1.0	0.00
10	Нитрат	<50.0	0.99
11	Төмөр	<0.3	0.12
12	Сульфат	<500.0	156.80
13	Хуурай үлдэгдэл	<1000.0	482.00
14	Натри+Кали	<200	42.39
15	Аммони	<1.5	0.10

### Хүнд металлын агууламж

Төслийн талбайн гүний худаас хүнд металлын 57 элементэд шинжилгээ хийлгэв. Тус шинжилгээний дүнгээс харахад Sr, Zn агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарч бусад элемент зөвшөөрөгдөх хэмжээнд байна.


Хүснэгт 6. Худгийн усан дахь хүнд металлын агууламж

Элемент	Al	Ba	Ca	Cr	Cu	Fe	K	Mg	Mn
Шинжилгээний арга	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t
Зөвшөөрөгдөх хэмжээ	10	10	0.05	10	5	50	0.1	0.05	5
Хэмжих нэгж	µG/L	µG/L	MG/L	µG/L	µG/L	µG/L	MG/L	MG/L	µG/L
Дээж-1	<10	<10	58.8	<10	<5	<50	1.7	37.3	<5

Элемент	Na	P	Sr	Ti	V	Zn	Be	Sc	Co
Шинжилгээний арга	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t	icp80t	ims80t	ims80t	ims80t
Зөвшөөрөгдөх хэмжээ	0.05	50	1	10	10	5	0.1	1	0.06
Хэмжих нэгж	MG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L
Дээж -1	43.9	<50	1419	<10	<10	454	<0.1	5	0.31

Элемент	Ni	Ga	Mo	As	Se	Rb	Y	Zr	Nb
Шинжилгээний арга	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t
Зөвшөөрөгдөх хэмжээ	0.3	0.02	0.1	0.03	0.2	0.01	0.005	0.05	0.005
Хэмжих нэгж	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L
Дээж -1	1.5	<0.02	9.2	<0.03	3.1	0.4	0.024	0.24	0.067

Элемент	Ag	Cd	In	Sn	Sb	Te	Cs	La	Ce
Шинжилгээний арга	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t	ims80t
Зөвшөөрөгдөх хэмжээ	0.2	0.01	0.001	0.1	0.2	0.1	0.001	0.01	0.05
Хэмжих нэгж	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L
Дээж -1	<0.2	<0.01	0.001	<0.1	<0.2	<0.1	0.013	<0.01	<0.05



Зураг 4. Гүний усны тэжээгдлийн мужийн зураг

### Усан хангамж

Энэхүү төсөл нь ахуйн хэрэгцээнд болон хөргөлтийн шугам, гал унтраах зорилгоор усыг ашиглана. Болзошгүй гал түймрийн аюул ослын үед зарцуулах усыг гал унтраах, усан хөргөлтийн автомат систем суурилуулсан байна./БНбд 21-0304/,

Ус хэрэглээний нормыг нарийвчлан хянаж, усыг ариг гамтай, үр ашигтай зарцуулах зорилгоор усны тоолуурыг стандарчлал, хэмжил зүйн газраар баталгаажуулж байх шаардлагатай. Терминалын жилийн ачаа эргэлтийн хүчин чадал нь 30-50 мян.тонн.

Усан хангамжийн тооцоог БОНХАЖЯ-ны сайдын 2015.07.30-ны өдрийн А/301 тоот тушаалын 10,12-р хавсралтад тусгагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” тушаалын дагуу тооцооллоо.

#### Хүснэгт 7. Агуулахын ус хэрэглээний тооцоо

№	Ус хэрэглээний төрөл	Тоо хэмжээ, хүн/хон	Норм,	Хоногийн хэрэглээ, м <sup>3</sup>	Сарын хэрэглээ, м <sup>3</sup>	Жилийн хэрэглээ, м <sup>3</sup>
1	Унд ахуйд	24	150 л/хон	3.6	108	1296
2	Гал унтраах насос станц		500м <sup>3</sup> -ын 2 сав			1000
3	Зам, талбай	900 м <sup>2</sup>	4.0 л	3600	-	108.0
	Нийт					2404

**Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвч**

*Хээрийн судалгаа:* “Трансгайд сервис” ХХК-ийн Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дахь газрын тосны бүтээгдэхүүний терминаль талбайн хөрсний төлөв байдлыг тодруулах зорилгоор хээрийн судалгаа хийсэн. Үүнд: Хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, хөрсөнд нөлөөлж буй хүчин зүйлс зэргийг тодруулж улмаар хөрсний хими, физик шинж чанарын төлөв байдлыг тодруулах зорилгоор нийт 5 цэгт судалгаа хийж, 10 ширхэг хөрсний дээж авсан.

*Лабораторийн задлан шинжилгээ:* Авсан дээжнүүдэд хими, физик шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг ШУА. Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид доорх аргаар тодорхойлов. Үүнд:


**Хүснэгт 8. Физик, химийн ерөнхий шинж чанар**

№	Хөрсний үзүүлэлтүүд	Задлан шинжилгээний арга
1	Ялзмаг	Тюрин
2	Урвалын орчин	Потенциометрийн (H <sub>2</sub> O, 1:5)
3	Карбонат	Эзэлхүүний
4	Хөдөлгөөнт фосфор	Мачигин
5	Хөдөлгөөнт кали	Дөлтфотометр
6	Цахилгаан дамжуулах чанар	Ионометр
7	Механик бүрэлдэхүүн	Качински

*Хүнд металлын аргазүй.* Хөрсөн дэх хүнд металлын шинжилгээг “SGS IMME Mongolia LLC” Стандартчилал хэмжилзүйн газраас (лаборатори TL №09) итгэмжлэгдсэн ISO/IEC 17025 стандартын шаардлага хангасан лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometeer (OS) –ийн багажаар тодорхойлуулсан.


*Зураглал:* “Трансгайд сервис” ХХК-ий Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дахь газрын тосны бүтээгдэхүүний терминаль талбайн газрын төлөв байдлын зургийг газарзүйн мэдээллийн системийн ArcGiS 10.4, Bing map болон бусад зураглалын програм хангамж дээр тулгуурлан Bing map satellite, өндрийн тоон мэдээ (DEM 90 m), сансрын зураг (Landsat TM), тофо зураг зэргийг ашиглан хийж гүйцэтгэсэн.

“Трансгайд сервис” ХХК-ийн Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дахь газрын тосны бүтээгдэхүүний терминаль талбайн нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их муж өргөргийн бүсшилтэй нутаг, Хархүрэн хүрэн хөрсний дэд бүс Мааньтын (4) тойрогт хамаарагдаж байна Зураг 1. (Үндэсний атлас 2009).



Зураг 5. Хөрс газарзүйн мужлалт

“Трансгайд сервис” ХХК-ий Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дахь газрын тосны бүтээгдэхүүний терминаль талбай орчим Хархүрэн хөрс тархсан байна (Зураг 7).



Зураг 6. Газрын тосны бүтээгдэхүүний терминал орчмын хөрсний зураг

Хархүрэн хөрс алаг өвс-үетэнт хуурай хээрийнургамалшил дор тогтворжих бөгөөд өвслөг ургамлын бүрхэц газрын гадаргын 50-80%-ийг эзэлнэ. Хархүрэн



хөрсний ус нэвчүүлэх чадвар сайн учраас хур борооны ус гүн нэвчдэг. Хархүрэн хөрсний дээд үе давхарга дахь ялзмагийн агууламж хөнгөн шавранцар хөрсөнд 3-5%, элс элсэнцэр хөрсөнд 2-3% байна. Доошоо огцом буурдаг. Урвалын орчин хөрсний дээд давхаргад сулавтар хүчиллэг буюу саармаг гүнрүүгээ шүлтлэг шинжтэй болж өөрчлөгдөнө. Хархүрэн хөрс агрохимийн шинжээр харьцангуй сайн, шим тэжээлийн элементийн агууламж хангалттай тул тус орны газар тариалангийн үндсэн эдэлбэр болж өгдөг. Энэ хөрсний 0-20 см гүн дэх ялзмагийн нөөц 60-80 тн/га, 0-50 см үе дэх ялзмагийн нөөц 100-130 тн/га хүрнэ.

Зүсэлтийн № ВН-01. Нефть хадгалах танкний урд талд хийсэн зүсэлт

Координат : N 47.367735 °  
E 107.47139°  
Өндөр : 1454 м д.т.д  
Дүүрэг : Багахангай  
Хороо : 2-р хороо  
Газрын гадарга : Татам  
Налуу (°) : Тэгш



Ургамал бүрхэц( %) : 50 – 60  
Голлох ургамал : хялгана  
Гадаргын чулуу : Хайрга  
Чулууны бүрхэц (%) : 40-50

*Хөрсний хэвшинж: Сайргархаг хархүрэн хөрс*

“А” 0 – 15 см гүнтэй, Чийгтэй, Хүрэн өнгөтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс олон, сайр дайрга чулуу 40-50%, нягтавтар, шилжилт чулуу болон өнгөөр.

“В” 15 – 40 см гүнтэй, Чийгтэй, цайвар хүрэн өнгөтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс цөөн, чулуу 20% орчим, нягт.

Зүсэлтийн № ВН-03. Талбайн баруун хойд талд хийсэн зүсэлт

Координат :N 47.369797° E 107.468128°  
Өндөр :1464 м д.т.д

Дүүрэг : Багахангай  
хороо : 2-р хороо

Газрын гадарга : Талархаг  
Налуу (°) : 1-3

Ургамал бүрхэц( %) : 40 – 50  
Голлох ургамал : хялгана

Гадаргын чулуу : Сайр  
Чулууны бүрхэц (%) : 0-5



*Хөрсний хэвшинж: Сайргархаг*  
*Хархүрэн хөрс*

“А” 0 – 15 см гүнтэй, Чийгтэй, Хүрэн өнгөтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс олон, сайр, дайрга чулуу 40-50%, нягтавтар, шилжилт өнгөөр тод.

“ВС” 15 – 40 см гүнтэй, Чийгтэй, цайвар бор өнгөтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, ургамлын үндэс цөөн, чулуу 20% орчим, нягт, карбонаттай.

Хөрсний хими, физик шинж чанар

“Трансгайд сервис” ХХК-ий Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дахь газрын тосны бүтээгдэхүүний терминаль талбай орчимд тархсан хөрсний хими шинж чанарыг хүснэгт 1. Хөрсний физик шинж чанарыг хүснэгт 2-д тус тус үзүүлэв.

Хөрс нь сул шүлтлэг урвалын (рН) орчинтой, 0-15 см-т бага зэрэг, 15-40 см-т их карбонат (CaCO<sub>3</sub>)-тай, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор (P<sub>2</sub>O<sub>5</sub>), калийн (K<sub>2</sub>O) хангамжаар 0-15 см-т дунд зэрэг, 15-40 см-т бага хангагдсан. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж (Хүснэгт 8).

**Хүснэгт 9. Хөрсний хими шинж чанар**

Дээжний дугаар	Гүн, см	рНН <sub>2</sub> O (1:2.5)	СаСО <sub>3</sub> %	Ялзмаг %	ЕС <sub>2.5</sub> dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
						P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
ВН-01	0-15	7.38	1.88	2.966	0.161	2.23	25.1
	15-40	7.64	22.22	0.935	0.150	1.06	12.4
ВН-03	0-15	7.38	0.40	4.275	0.179	2.87	29.3
	15-40	7.59	21.81	0.467	0.273	0.62	8.5


Дээд үе давхарга болох 0-15 см гүндээ чулууны агууламж өндөр буюу 40-50% орчим, 15 см доош чулууны агууламж буурч 20% болж байна. А үе давхарга болох 0-15 см гүнд эзлэхүүн жин бага (1.19-1.24 г/см<sup>3</sup>) буюу нягтавтарт бол 15-40 см гүнд нилээд нягт буюу 1.36-1.40 г/см<sup>3</sup> байна. Хөрсний бүх үе давхарга элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна (Хүснэгт 6).

Хүснэгт 10. Хөрсний физик шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	Чулуу (%)	Эзлэхүүн жин (г/см <sup>3</sup> )	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)			Механик бүрэлдэхүүн
				Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (<0.002мм)	
ВН-01	0-15	45	1.24	65.8	22.7	11.5	Элсэнцэр
	15-40	20	1.36	68.7	20.5	10.8	Элсэнцэр
ВН-03	0-15	45	1.19	69.5	15.4	15.2	Элсэнцэр
	15-40	20	1.40	70.2	14.6	15.2	Элсэнцэр

### Хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэл, бохирдолын өнөөгийн түвшин Хөрсний элэгдэл, эвдрэл

“Трансгайд сервис” ХХК-ийн Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутагдахь газрын тосны бүтээгдэхүүний терминаль талбайд бүтээн байгуулалтын нөлөөгөөр нийт 4.23 га талбай эвдрэл, доройтолд өртсөн байна. Үүнээс доройтолд орсон 1.53 га талбай, бүрэн эвдэрсэн 2.7 га талбай байна. Байшин барилгаар 0.26га, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зорилгоор 0.42га, сайжруулсан замаар 0.6га, чулуун хучаастай талбай 1.25га төмөр зам 0.64га, хатуу хучилттай талбай 0.68га, хаягдлын далан 0.17га талбай тус тус ашиглалтын нөлөөгөөр эвдэрч доройтсон байна (Зураг 8).



Зураг 7. Төслийн талбай орчмын хөрсний эвдрэл

### Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан нөмрөг

Ургамлын судалгааг хөрс судлагчтай хамт явж, 1:25000-ны масштабын байрзүйн зураг ашиглаж, хөрсний зүсэлт хийсэн газруудын цэгийг ургамлын бичиглэлтэй хамтатган бичсэн. Мөн үүнээс гадна өөрийн сонирхсон газруудад ургамлын нэмэлт бичиглэл хийлээ. Судалгааны дүнг нэгтгэж доор дурдсан ургамлын бүлгэмдлийг зохиолоо./БОННУ-2023/ Үүнд :

А. Бэсрэг уулсын ургамалжилт

Бэсрэг уулсын (нам уулс, ухаа гүвээ толгодын ургамалжилт) ургамалжилтыг газрын гадарга, ургамлын тархалтыг үндэслэн 2 ангилж болох юм. Үүнд :

1. Нам уулс, ухаа гүвээ толгодын хормой бэлээр хүрэн хөрстэй гадаргад тархсан алаг өвс-үетэнт, хялгана- үетэн-алаг өвст бүлгэмдэл
2. Нам уулс, ухаа гүвээ толгодын орой хяраар тархсан чулуутай гадаргад тархсан-Хялгана-үетэн-алаг өвст, үетэн-алаг өвс-хазаарт бүлгэмдэл

Б. Уулсын хоорондох тал хөндийн ургамалжилт

Дунд зэргийн зузаан давхрагатай үүрмэг чулуутай хүрэн хөрстэй гадаргад: тал хээрийн ургамал хялгана, алаг өвс-хазаар-алаг өвст бүлгэмдэл.

Бүлгэмдэл тус бүрийн онцлогыг авч үзье.



Зураг 8. Нам уулс, ухаа гүвээ толгодын орой хярын ургамалшил (2020 оны 3-р сар)

1. Нам уулсын хажуу бэлээр Алаг өвс-үетэнт, хялгана-үетэн-алаг өвст эвшилүүд, жижиг толгодын энгэр хормойгоор хялгана-алаг өвст, алаг өвс-хялганат, бүлгэмдлүүд зонхилно.

Энд үетнээс: Крыловын хялгана /*Stipa Krylovill*, Ленийн ботууль /*Festuca lenenstsi*/, хиаглай түнх /*Leymus chinensis*/, саман ерхөг /*Agropyron cristatum*/, дааган сүүл /*Koelleria cristata*/, зулын биелэг өвс /*Poa attenuata*/, алаг өвснөөс /бэриш/, дагуурын хатны цэцэг, үлд өвс /*Orostachys spinesal*/, эгэл ерөмтүүл /*Galium verum*/, хурдан цагаан /*Areniarea capilaris*/, ганга өвс /*Thymus gobical*/, нумираа хунчир /*Astragalus adsurgenes*/, уул өвс /*Leontopodium ochroleucum*/, цөс өвс /*Thalctrum symplexl*/, шар царгас /*Medicago falcafa*/ бугын зогдор /*Carex*

*pediformus*/ зэрэг ургамал ургана. Ургамлын тусгаг бүрхэц одоогийн байдлаар 35%-40 ургамлын дундаж өндөр дунджаар 7-14 см.

2. Нам уулс, ухаа гүвээ толгодын орой хяраар тархсан чулуутай чулуутай гадаргад тархсан-Хялгана-үетэн-алаг өвст, үетэн-алаг өвс-хазаарт бүлгэмдэл

Үетнээс: Крыловын хялгана /*Stipa Krylovii*, Ленийн ботууль /*Festuca lenensts*/, хиаглай түнх /*Leymus chinensis*/, саман ерхөг /*Agropyron cristatum*/, дааган сүүл /*Koelleria cristata*/, зулын биелэг өвс /*Poa attenuata*/,

Алаг өвснөөс: бэриш, дагуурын хатны цэцэг, үлд өвс /*Orostachys spinesal*/, эгэл өрөмтүүл /*Galium verum*/, хурдан цагаан /*Areniarea capilaris*/, ганга өвс /*Thymus gobical*/, нумираа хунчир

/*Astragalus adsurgenes*/, хазаар өвс / *Cleistogenes sguarrosa*/, башир цэцэг /*Duanthus versicolor*/, шар царгас /*Medicago falcafa*/, бугын зогдор /*Carex pediformus*/ зэрэг ургамал ургана. Ургамлын тусгаг бүрхэц одоогийн байдлаар 35%-40 ургамлын дундаж өндөр дунджаар 8-21 см.

Б. Уулсын хоорондох тал хөндийн ургамалжилт

Дунд зэргийн зузаан давхрагатай үүрмэг чулуутай хүрэн хөрстэй гадаргад: тал хээрийн ургамалан нөмрөг хялгана, алаг өвс-хазаар-алаг өвст бүлгэмдэл.



Зураг 9. Уулсын хоорондох тал хөндийн ургамалшил

Дунд зэргийн зузаан давхрагатай үүрмэг чулуутай хүрэн хөрстэй тал хээрт хялгана-алаг өвст, хазаар-алаг өвст бүлгэмдэл. Уулсын хоорондох тал хөндийд тархсан дунд зэргийн зэргийн зузаан давхрагатай хүрэн хөрсний ургамлын нөмрөг нь дээр бичсэн ургамалшилтай бараг адилхан юм.

Энд голлох ургамал нь гэвэл: Хазаар өвс /*Cleistogenes sguarrosa*/, хялгана /*S. capillata*/, Саман ерхөг-*Agropyrum cristatum*, адамсын шарилж-*Artemisia adamsii*, гол гэсэр-*Aster bienis*, ишгэн шарилж-*Artemisia dracuncul*, багдай *Dontostemon*, согсоолж -*Heteropappus hispidus* агь-*Artemisia frigida*, цагаан дэмэг *Allysum*, хүж өвс-*Haplophyllum dahuricus*, гашуун банздоо-*amara*, имт гичгэнэ- *Potentilla bifurca*, сүүт өвс-*Euphorbia discolor*-жижиг навчит харгана-*Cargana mycropylla* зэрэг ургамал ургана.

### Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Тус төслийн талбайд уулын хээрийн тэгшивтэр тал хөндийн (д.т.д 1459) ландшафтын хэв шинж илэрч байна. Төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалтаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын хээрийн мужид хамаарагдана.

Монгол орны ургамал газарзүйн тойрог

Ургамлын аймаг, ургамалжилтын судалгааны үр дүнд төслийн талбайд ландшафтын онцлогоос хамааран бүхэлдээ 1 хэв шинжид хамаарагдах хар хүрэн хөрстэй хуурай хээрийн Хялгана-алаг өвст бүлгэмдэл /У-IV-2-5,36/ бүлгэмдэл тархсан байна.

Хүснэгт 11. Бэлчээрийн төрлийн нэр, ангилал

Индекс	Бэлчээрийн төрлийн ангиллын шифр	Бэлчээрийн төрлийн нэр
1	2	3
Төслийн талбайн ургамалжилт		
Төрөл: У- Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр		
У-IV		Анги: Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр
36	У-IV-2-5	Хялгана-алаг өвст бүлгэмдэл

Тус төслийн талбайд ландшафтын хувьд хуурай хээрийн ургамалжилт давамгайлсан тархсан бөгөөд хуурай хээрт олон наст үет ургамлын бүлгэмдэлд үзүүлэх үүрэг эрс өсдөг. Ургамлын бүрхэц нийт талбайн хэмжээнд дунджаар 70-75 хувийн бүрхэцтэй, дундаж өндөр олон наст үет ургамал 20-25 см, нэг наст болон алаг өвс 15-18 см өндөр ургасан байна.

### Төсөл хэрэгжих талбай орчмын амьтны аймаг

Энэ районд Монголын шинжлэх ухааны академийн ажилчид 1960-1980 оны хугацаанд хэд хэдэн удаа хайгуулаар ирж, амьтны аймгийн судалгаа хийж байсан юм. Судлаачдын замын тэмдэглэл, нийтлэгдсэн бүтээлүүдэд амьтдын талаар орсон баримт материалыг үндэслэн тус нутгийн амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүний жагсаалтыг үйлдэн амьтан бүрийн тоо толгойн байдал, орших хэлбэр, амьдрах орчин, идэш тэжээлийн онцлог, байгаль эдийн засгийн үнэлгээг доор үзүүлэв.

Хоёр нутагтнаас энэ районд зөвхөн монгол бах /Sibrian Sand or Raddes Toad/, мөлхөгчдөөс энд бамбай хоншоорт могой /Halys or Central Asian Viper/ бий. Энэ нутагт агнуурын ач холбогдолтой 16 зүйлийн хөхтөн амьтан, 22 зүйлийн шувуудтай. Тус сумын нутагт агнуурын амьтдаас үнэг, саарал чоно, дорго, өмхий хүрэн, бор туулай, дагуурын ятуу бусдаас элбэг юм. Орших хэлбэрийн хувьд нийт хөхтөн амьтдын 14 зүйл ичээнд ордог, 25 зүйл жилийн 4 улирлын идэвхтэй. Ховорт 20 зүйл, элбэгт 19 зүйлийн хөхтөн амьтан тооцогдоно.

Энэ районд тоо толгойн хувьд хэт олширдог шавьж мэрэгчдийг идэж цөөрүүлдэг 12 зүйлийн хөхтөн, 91 зүйлийн шувуу, 65 зүйл шавьж бий. Байгаль

дахь амьтдын тэнцвэрт байдлыг зохицуулдаг эдгээр зүйл амьтдаас үзүүлж буй ач тус асар их байгаа нь ойлгомжтой. Мөнгөөр үнэлэх бололцоогүй юм. Элдэв халдварт өвчин эмгэгээр үхсэн амьтдын хүүр зэмийг идэж, устган байгалийг ариутгадаг тас, сохор элээ, чоно мэт махчин амьтад энэ нутагт түгээмэл юм. Дагуурын ятуу мэт ургамлын үр иддэг олон зүйл шувууд бэлчээр, тариалангийн талбайн хог ургамлын үрийг ихээр хороодгоороо ашигтай. Үлийн цагаан оготно, монгол чичүүл мэт үе үе хэт олширдог мэрэгчдийг хороор устгахгүй болсон өнөө үед энэ нутагт буй 16 зүйлийн махчин шувууд ихээхэн ач холбогдолтой болно.

Энэ нутагт тархсан амьтдын экологи–эдийн засгийн үнэлгээг Засгийн газрын 1995 оны 152 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг баримтлан гаргав. Тус хавсралтын дагуу экологи–эдийн засгийн үнэлгээг гол төлөв агнуурын ач холбогдолтой 14 зүйлийн хөхтөн, 42 зүйл шувуунд өглөө (хүснэгт 12).

**Хүснэгт 12. Амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн**

Mammalia хөхтөн	Ичдэг	Тоо толгой	Амьдрах орчин	Тэжээл	Гаргах зулзганы тоо	Экологи эдийн засгийн үнэлгээ /мян.төг/
1	2	3	4	5	6	7
Insectivora						
Erinaceus dauricus Sund, 1841 Daurian Hedgehog дагуурын зараа	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Ойн зах чөлөө, нуга голын татам, өтгөн өвст хээр	Шавьж, огтоно, гүрвэл, могой, ангаахай	5-6	Монголын улаан номонд орсон зүйл.
Sorex daphaenodon Tho. 1907 Large-toothed Shrew Бэсрэг атаахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Ой, голын шугуй, нуга өндөр өвст хээр	шавьж хорхой	-10	Шавьж хороодгоор ашигтай.
Sorex vir GL Allen, 1914 Flat-skulled Shrew Тавшгар атаахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Хус, бургас, холимог ой, энгэрийн бут сөөг.	Шавьж хорхой	-10	Шавьж хороодгоор ашигтай
Sorex tundrensis Merria 1900 Boreal Shrew Цармын атаахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Голын хөндий, шугуй, ойн зах	Шавьж хорхой	-10	Шавьж хороодгоор ашигтай.
Sorex minutissimus Zim , 1980 Laast Shrew Өөдсөн атаахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Голын хөндий, шугуй, ойн зах	Шавьж хорхой	-6	Шавьж хороодгоор ашигтай
Sorex minutus L., 1776 Lesser Shrew Хонин атаахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Хус, бургас сайр	Шавьж хорхой		Шавьж хороодгоор ашигтай.
Crocidura suareolens Pall 1811 Scilly Shrew Хонин малтаахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Ховор	Бут, сөөг, дов сондуул, хусан ой.	Шавьж хорхой		Шавьж хороодгоор ашигтай
Chiroptera						
1	2	3	4	5	6	7
Myotis daubentoni Kuhl 1818 Daubentons or Water Bat Усны багваахай	Өвөл ичдэг шөнийн идэвхтэй	Элбэг	Хад агуй, усны орчим	Нисдэг цох, ялаа		Шавьж хороодгоор ашигтай.
Myotis mystacinus	Ичдэг	Ховор	Бургас,	Нисдэг		Шавьж

Kuhl 1819 Whiskered Bat Сахалт багваахай	шөнийн идэвхтэй		улиасан шугуй, дээврийн хөндий хадны ангал, ус орчим .	цох,ялаа		хороодгоор ашигтай
Eptesicus nilssoni Keys 1839 Northern Bat Сахалт багваахай	Ичдэг шөнийн идэвхтэй	Элбэг	Улиас, шинэс, хадны ангал, ус орчим	Нисдэг цох, ялаа		Шавьж хороодгоор ашигтай
Lagomorpha						
Ochotona daurica Pall 1776 Daurian Pika дагуур огдой	Ичдэггүй	Элбэг	Хээр тал Улиас, шинэс, хадны ангал, ус орчим	Өвс	6	
Lepus timidus L., 1758 Mountain Hare Чандага	Ичдэггүй	Ховор	Ойд	Бургас, өвс, хус		0,3
Lepus toloi Pgl., 1778 Tolai Hare Бор туулай	Ичдэггүй	Элбэг	Голын хөндий, хээр тал, уулын энгэр, жалга, бургасан шугуй	Өвс, бут, бургасны мөчир		Агнуурын амьтан махчдын хоол болно 0,3
Marmota sibirica Radde., 1862 Siberian Marmot Монгол тарвага	Ичдэг	Ховор	Хээр тал, уулсын энгэр	Өвс	5	Агнуурын амьтан махчдын хоол болно 0,8
Citellus undulafus Long-failed Souslik Урт сүүлт зурам	Ичдэг	Элбэг	Ойн зах, энгэр, бэл	Өвс, царцаа.	6-7ш	Агнуурын амьтан махчдын хоол болно. 0,1
Phodopus sungorus Pall., 1773 Dwarf Hamster Орог зураг	Ичдэг, шөнийн идэвхтэй	Элбэг	Хээр тал, уулын бэл	Өвс, шавьж	6-9ш	Махчдын хоол
Cricetulus pseudoqriseus Orl 1975 Transbaikal Hamster Байгалийн шишүүхэй	Ичдэг, шөнийн идэвхтэй	Ховор	Сийрэг ой, бут, элсэн хөрстэй газар	Өвс шавьж	6-9ш	Махчдын хоол
Clethrionomys rufocanus Sund., 1846-1847 Grey- sided Vole Ойн хүрэн оготно	Ичдэггүй	Элбэг	Ой, ойн захын ширэнгэ, голын шугуй	Өвс навч, жимс	7-8ш	Махчдын хоол
Microtus maximowicrii Schr., 1958 Maximkovich;s Vole Ширчийн оготно	Ичдэггүй	Элбэг	Голын дагуу	Өвс, үр үндэс	3-8ш	Махчдын хоол
Microtus mongolicus Radde 1861 Mongolian Vole Монгол оготно	Ичдэггүй	Элбэг	Чийгтэй нуга	Өвс	5-6ш	Махчдын хоол
Lasiopodomys brandti Radde 1861 Brandt;s Vole Үлийн цагаан оготно	Ичдэггүй	Элбэг	Хээр тал	Өвс,үндэс	6-8ш	Бэлчээрийн хортон, бусад амьтдын хоол
Meriones	Ичдэггүй	Элбэг	дэнж, бэл	Өвс	12ш	Халдварт өвчин,



unguiculatus Miehe 1867 Mongolian Gerbil Монгол чичүүл			хуурайлтар хөрстэй гуу жалга, суурин газрын хог			тахал тараагч
